

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/08/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Сүнжидмаа
Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn



ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА П.АВИРМЭД ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 130

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны зардлын нийт гүйцэтгэл өмнөх оноос 823.8 сая төгрөг буюу 25.0 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосонтой холбоотой байна

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг хүргүүлжээ.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 8 зорилт 173 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 84.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702900424

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл		/мян.төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	972,439.8	1,038,842.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,583,650.0	4,011,411.4
	Нийт хөрөнгийн дүн	4,556,089.8	5,050,235.8
	Нийт өр төлбөрийн дүн	1,253.6	1,028.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,554,836.3	5,049,207.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,556,089.8	5,050,235.8
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,084,244.0	2,138,777.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,028,559.0	1,642,421.6
	Үйл ажиллагааны үр дүн	1,055,685.0	494,371.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	2,152,071.4	1,985.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(1,096,386.4)	494,371.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,651,222.7	4,554,836.3
	Тайлант оны үр дүн	(1,096,386.4)	494,371.1
	Эцсийн үлдэгдэл	4,554,836.3	5,049,207.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,478,341.8	1,888,389.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,125,933.2	1,477,690.4
	Үйл ажиллагааны ЦМГ	352,408.6	410,698.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	171,365.0	251,266.7
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(256.0)	(78,485.0)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	180,787.6	80,946.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	239,408.4	420,196.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	420,196.0	501,142.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,591,624.4
	Урсгал зардал	1,209,040.0	1,231,096.6
	Хөрөнгийн зардал		360,527.8
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	1,209,040.0	1,231,096.6
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,591,624.4

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 643,001.2 мянган төгрөгийн 9 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна

Залруулагдаагүй нийт 4,458.5 мянган төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс, 2,473.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,985.0 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 4,458.5 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 32800.0 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 Суурин дулаан аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 3 тусгай сан, 4

байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ, Суурин дулаан аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

5.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 81,435.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 1,985.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

5.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 113,245.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 2,372.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

5.1.4 Аудитаар дүгнэлт өгсөн Суурин дулаан аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар нийт зарлагыг 371,875.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 130.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 76,444.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 1 алдааг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 4,458.5 сая төгрөгийн 1 зөрчил илрүүлснээс 1 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж байна.

5.2.1 Албан шаардлага

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 4,458.5 мянган төгрөгийн төгрөгийн 4 зөрчил илэрч 2,473.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,985.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6.АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		
							Залруулсан		Залруулаагүй
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Жаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	76,444.5	-	-	1	76,444.5	1	76,444.5	-
Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар	3	113,245.10	-	-	3	113,245.10	3	113,245.10	-
Жаргалан сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	81,435.80	-	-	2	81,435.80	2	81,435.80	-
Жаргалан сумын Суурин дулаан ААТҮГ	3	371,875.80	1	650.0	2	371,225.80	3	371,875.80	-
Дүн	9	643,001.2	1	650.0	8	642,351.2	9	643,001.2	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүншилт өгөхөөс	Түвшэрт	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:			
							Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар	1	-	1	-	-	-	1	2,342.6	1	2,342.6		
Жаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Жаргалан сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	-	1	1	1,985.0		1,985.0	1	
Жаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Жаргалан сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Жаргалан сумын Суурин дулаан ААТҮГ	1	-	1	-	-		1	130.0	1	130.0	-	-
Дүн	7	1	2	-	-	4	3	4,458.6	2	2,473.6	1	1,985.0
											-	-

6.3 Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			Тоо					
Жаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	-	-	-	-	-	-	-	-
Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар	3	75,549.0	-	-	3	75,549.0	-	-
Жаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	18,000.0	-	-	2	18,000.0	-	-
Жаргалан сумын Суурин дулаан ААТҮГ	1	1,465.7	-	-	1	1,465.7	-	-
Дүн	6	95,014.7	-	-	6	95,014.7	-	-

Хяналтын алба
Х.Б. Төсвийн АН, ИТНН
ГЗМР